9	Явах хурд	4.5 км/цаг
10	Дэвсэгч	Бүрэн автомат
11	Үйлдвэрлэсэн он	2020 он

**3. Индуу /4 тн/**

1	Хөдөлгүүрийн хүчин чадал	35KW
2	Ажлын жин	4 тн
3	Дугуй хоорондох зайд	3180 мм
4	Эргэлдэгч булны өргөн	1300 мм
5	Хамгийн бага эргэлтийн радиус	2900/4200
6	Үйлдвэрлэсэн он	2020 он

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ**  
**ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

**ГАРЧИГ**

1. Нэр томъёо
2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах
3. Захиалгыг өөрчлөх
4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах
5. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах
6. Барааны гарал үүслийн улс
7. Шалгалт, туршилт
8. Баглаа боодол
9. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт
10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх
11. Гүйцэтгэлийн баталгаа
12. Даатгал
13. Чанарын баталгаа, баталгаат засвар
14. Төлбөр
15. Үнэ
16. Хуваарийг сунгах
17. Алданги оногдуулах
18. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах
19. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах
20. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах
21. Маргааныг шийдвэрлэх
22. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал
23. Гэрээний үүргийг шилжүүлэх
24. Гэрээнд ашиглах хэл
25. Татвар, хураамж
26. Гарчиг
27. Үүргийн гүйцэтгэл

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Нэр томъёо</b>  | <p>1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>(а) “гэрээ”гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд байгуулсан бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.</li><li>(б) “гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн болон зохих хэмжээнд гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.</li><li>(в) “бараа” гэж нийлүүлэгчээс захиалагчид гэрээний дагуу нийлүүлэх тоног төхөөрөмж, машин механизм болон бусад материалыг хэлнэ.</li><li>(г) “бусадүйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, угсралт, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн үзүүлэх аливаа дагалдах ажил, үйлчилгээ, үүргийг хэлнэ.</li><li>(д) “захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.</li><li>(е) “нийлүүлэгч” гэж гэрээнд заасан бараа, үйлчилгээг нийлүүлж буй этгээдийг хэлнэ.</li><li>(ж) “ажлын талбай” гэж гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон газрыг хэлнэ.</li><li>(з) “хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.</li></ul> |
| <b>2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах</b> | <p>2.1. Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлаж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.</p> <p>2.2. Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч 2.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.</p> <p>2.3. 2.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө.</p> <p>2.4. Захиалагчийн нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй.</p>   |
| <b>3. Захиалгыг өөрчлөх</b>   | <p>3.1. Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний ерөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг хэдийд ч өөрчлөх эрхтэй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>(а) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар зураг, зураг</li></ul>  |

		төсөл, техникийн тодорхойлолтыг өөрчлөх;
	(б)	тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр;
	(в)	барааг хүргэх газар.
3.2.		Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид “өөрчлөлт” гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаанд үзүүлэх нөлөөг (хэрэв нөлөөлөх бол) харгалzan түүний зардлын нарийвчилсан тооцоо, хэрэгжүүлэх хуваарийг гаргаж, өөрчлөлтийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор захиалагчид танилцуулна.
3.3.		Захиалагч 3.2-т дурдсан нийлүүлэгчийн тооцоог үндэслэж өөрчлөлтийг бичгээр батлах ба ийнхүү баталгаажуулах хүртэл нийлүүлэгч 3.1-д дурдсан өөрчлөлтийг гүйцэтгэхгүй.
3.4.		Харилцан тохиролцсон өөрчлөлт нь гэрээний хэсэг болох ба энэ өөрчлөлтөд гэрээний нөхцөл, болзол үйлчилнэ.
<b>4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах</b>	4.1.	Энэхүү гэрээний 3 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.
<b>5. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах</b>	5.1.	Захиалагч урьдчилж бичгээр зөвшөөрөөгүй тохиолдол нийлүүлэгч гэрээ болон түүний аль нэг хэсгийг туслан гүйцэтгүүлэх зорилгоор туслан гүйцэтгэгч сонгож түүнтэй гэрээ байгуулж болохгүй.
	5.2.	Нийлүүлэгч гэрээг хэрэгжүүлэхдээ сонгосон аливаа туслан гүйцэтгэгч нь өөрийн хариуцсан ажил үүрэгт ногдох гэрээний холбогдох нөхцөл, болзлыг бүрэн биелүүлэхийг батламжилна.
<b>6. Барааны гарал үүслийн улс</b>	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.
	6.2.	Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.
<b>7. Шалгалт болон туршилт</b>	7.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Гэрээний тусгай нөхцөлд эсвэл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгч(д)ийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.
	7.2.	Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар, барааг хүргэх газар болон эцсийн цэгт явуулж болно. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар явуулсан тохиолдолд захиалагчийг шаардлагатай байгууламж, зураг, үйлдвэрлэлийн өгөгдөл болон бусад

- 7.3. туслалцаагаар үнэ төлбөргүй хангана.
- 7.4. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.
- 7.5. Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсний дараа түүнийг дэхин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох захиалагчийн эрхийг хөндөхгүй.
- 8. Баглаа боодол**
- 8.1. Энэ зүйлийн аль ч нөхцөл, болзол нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.
- 8.2. Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тундас зэргийг хангалттай тээвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгоходоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.
- 8.3. Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ гэрээнд, нэн ялангуяа гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрднө.
- 9. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**
- 9.1. Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулга, хувилбарыг хэрэглэнэ. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ.
- 9.2. Гэрээнд хэрэглэсэн CIP /СИП/, EXW /ИКСБ/, FOB /ФОБ/, FCA/ФСА/, CIF /СИФ/ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
- 10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх**
- 10.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглах явцад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн тохиолдолд гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.
- 11. Гүйцэтгэлийн баталгаа**
- 11.1. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан мөнгөн дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.

- 11.2. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нөхөж барагдуулахад уг баталгаа зориулагдана. Гэрээний гүйцэтгэлийг ГЕН-ийн 16.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.
  - 11.3. Гүйцэтгэлийн баталгаа нь ТОӨЗ-ны 16 дугаар зүйлд заасан валютаар гаргасан банкны баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр гаргасан баталгаа байна.
  - 11.4. Нийлүүлэгч гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг дуусгавар болгосноос хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.
- 12. Даатгал**
- 12.1. ГТН-д тусгайлан өөрөөр заагаагүй бол барааг үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг ГТН-д заасан хэлбэрээр инкотермсийн нөхцөлийн дагуу даатгуулна.
- 13. Чанарын баталгаа, баталгаат засвар**
- 13.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согоггүй бөгөөд хамгийн суулийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна. Өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бараа нийлүүлэхэд ашиглах бүх материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэрэг нь шинэ, сайн чанарын болон зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна.
  - 13.2. ГТН-д өөрөөр заагаагүй бол баталгаат засвар нь барааг хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сар, эсхүл барааны гарал үүслийн улсын боомтоос ачсан өдрөөс хойш 18 сар гэсэн хугацааны аль эрт дуусах хугацаанд хүчинтэй байна.
  - 13.3. Захиалагч энэхүү баталгаатай холбогдох гомдлыг нийлүүлэгчид бичгээр шуурхай мэдэгдэнэ.
  - 13.4. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой бараа, эсхүл түүний эд ангийг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.
  - 13.5. Захиалагч нь 13.2 заасныг үл харгалзан, 13.4-т заасны дагуу гэмтэл согогийг арилгаснаас хойш 12 сарын дотор засварласан бараанд энэ төрлийн гэмтэл согог дахин гарсан тухай бичгээр мэдэгдэл ирвэл уг гэмтэл согогийг үнэ төлбөргүй шуурхай арилгана.
  - 13.6. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй. Энэ зүйлд заасны дагуу нийлүүлэгчийн гаргах баталгаа нь гэрээнд заасан захиалагчийн бусад эрх, үйл ажиллагааг хязгаарлахгүй.
- 14. Төлбөр**
- 14.1. Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг ГТН-д дурдана.

- 14.2. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон ГЕН-ийн 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.
- 14.3. ГТН-д өөрөөр заагаагүй бол захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээнавснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.
- 14.4. Гэрээний дагуу нийлүүлэгчид хийх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.
- 15. Үнэ**
- 15.1. Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана. ГТН-ийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах, эсхүл ГЕН-ийн 3 дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвөл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.
- 16. Хуваарийг сунгах**
- 16.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 16.2. Нийлүүлэгч дараах тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:
- (а) захиалагч ГЕН-ийн 3 дугаар зүйлд заасны дагуу захиалгыг өөрчилсөн;
  - (б) захиалагчаас гаргаж өгөх материал, зураг, эсхүл үйлчилгээ хугацаа хоцорсон (үйлчилгээ гэдэгт гэрээний дагуу захиалагчийн гаргах зөвшөөрөл, баталгаа орно);
  - (в) ГЕН-ийн 22 дугаар зүйлд заасан гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүсвэл;
  - (г) захиалагчийн өгсөн захиалгаас шалтгаалан ажлын гүйцэтгэл хойшилсон.
- Нийлүүлэгч хугацаа хоцрохоос урьдчилан сэргийлэхийн тулд бололцоотой бүхнийг хийсэн гэдгийг захиалагчид нотлон харуулах үүрэгтэй. Хугацаа хоцролтын шалтгааныг арилгах, даван туулах арга замуудыг талууд хэлэлцэнэ.
- 16.3. Гүйцэтгэгч 16.2-т заасан нөхцөл байдал бий болсны улмаас бараа нийлүүлэлтийн хуваарь ямар нэг байдлаар хоцорч болох тухай захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдээгүй, эдгээр нөхцөл байдал бий болсныг нотлон харуулаагүй тохиолдолд 16.2-ыг үл харгалзах ба хуваарийг сунгахгүй.
- 17. Алданги оногдуулах**
- 17.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг уг хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэх ёсгүй. Дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалагч ГЕН-ийн 18 дугаар зүйлийн дагуу цуцлах тухай асуудлыг хөндөж болно.
- 18. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:

		<ul style="list-style-type: none"> <li>(а) нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй;</li> <li>(б) нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаарлага хангаагүй бөгөөд гэрээний бусад үүргээ биелүүлээгүй;</li> <li>(в) нийлүүлэгч 18.1.(а), 18.1.(б)-д заасан нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг захиалагчаас хүлээн аваад 10 хоногийн дотор (захиалагч үүнээс урт хугацаа заах эрхтэй) алдаагаа залруулаагүй;</li> <li>(г) нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авлигат, залилан мэхлэх зохиомол тохиролцоо хийх болон айлган сүрдүүлэх үйлдэлд холбогдоноыг шүүх, эсхүл эрх бүхий байгууллага тогтоосон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална.</li> </ul>
	18.2.	18.1-ийн дагуу гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд захиалагч нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр захиалагч худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогдон гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна. Энэ зүйлийг үл харгалзан нийлүүлэгч гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
<b>19. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах</b>	19.1.	Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ингэхдээ захиалагч нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй. Гэвч ийнхүү цуцалсан нь захиалагчид үүссэн эсвэл ирээдүйд үүсэх аливаа эрхийг, хөндөхгүй.
<b>20. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах</b>	20.1.	Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. <sup>6</sup> Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсон үндэслэл болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана.
	20.2.	<p>Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хөёуланг хэрэгжүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>(а) үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцөлөөр авах, болон/эсхүл</li> <li>(б) үлдэх барааг цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дүнд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно.</li> </ul>

<sup>6</sup> Захиалагч гэрээг цуцлах шийдвэрийг холбогдох дээд шатны байгууллагын зөвшөөрөлтэйгээр зөвхөн зайлшигүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гаргана.

<b>21. Маргааныг шийдвэрлэх</b>	21.1. Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцэл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ.
	21.2. Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал ГТН-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.
<b>22. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал</b>	22.1. Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.
	22.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
<b>23. Гэрээний үүргийг шилжүүлэх</b>	23.1. Ямарч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
<b>24. Гэрээнд ашиглах хэл</b>	24.1. Нийлүүлэгч ГТН-д заасан гэрээнд ашиглах хэлийг бүрэн ойлгох мэдлэгтэй гэдгээ үүгээр баталж байна. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна. 24.2. 24.1-д заасан хэл рүү орчуулах зардал болон орчуулгын үнэн зөвийг нийлүүлэгч хариуцна.
<b>25. Татвар болон хураамж</b>	25.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оногдуулдаг бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.
<b>26. Гарчиг</b>	26.1. Гэрээний бүлэг, зүйл болон бусад хэсгийн гарчиг нь зөвхөн тайлбарын шинжтэй бөгөөд гэрээний хэсэг болохгүй.
<b>27. Үүргийн гүйцэтгэл</b>	27.1. Аль нэг тал нь гэрээний үүргээ гүйцэтгэхийг хатуу шаардаагүй нь нөгөө талын уг үүргийг биелүүлэхгүй байх шалтгаан болохгүй.

### ДОЛОО ДУГААР БҮЛЭГ

### ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 
- |                                     |         |   |
|-------------------------------------|---------|---|
| <b>1. Тодорхойлол т (ГЕН - 1)</b>   | 1.1.(д) | Захиалагч нь “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ |
| <b>2. Шалгалт туршилт (ГЕН - 7)</b> | 7.0     | <i>Шаардлагатай</i>   |

3. Баглаа боодол (ГЕН -	8.0	<b>Барааг тээвэрлэхэд гэмтэл учрахгүй байхаар баглаа боодолтой байна.</b>
4. Барааг хүргэх болон бичиг баримтын бүрдүүлэлт (ГЕН - 9)	9.0 9.3	<p>ГЕН-ийн 9 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<sup>7</sup></p> <p>“Монгол Улсын гаднаас санал болгосон бараа (жишээлбэлСИП):</p> <p>Нийлүүлэгчбараагтээврийнхэрэгсэлдачсаныдарааэнэтуха йбүрэнмэдээллийг захиалагч болондаатгалынбайгууллагадутсанхолбоогоормэдэгдэнэ. Мэдэгдэлд гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, тээврийн хэрэгслийн нэр, тээврийн баримтын дугаар, ачсан боомт, боомтоос гарах огноо, буулгах боомт зэргийг дурдана. Нийлүүлэгч дараах баримт бичгийг<sup>8</sup> захиалагч болон даатгалын байгууллагад шуудангаар илгээнэ:</p> <ol style="list-style-type: none"> <li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li> <li>2) барааг бүрэн бүтэн усан онгоцонд ачуулсан болохыг гэрчлэх “Тээврийн хөлс урьдчилан төлөгдсөн” гэсэн тэмдэглэл бүхий бусдад шилжүүлж болох ачааны нэхэмжлэх (bill of lading)-ийн үндсэн болон 1 ширхэг хуулбар хувийг бусдад үл шилжүүлэх ачааны нэхэмжлэхийн 1 ширхэг хуулбар хувийн хамт;</li> <li>3) барааны багц бүрийн баглаа боодлын жагсаалт;</li> <li>4) даатгалын гэрчилгээ;</li> <li>5) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li> <li>6) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалт туршилтын гэрчилгээ;</li> <li>7) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li> </ol> <p>Энд жагсаасан бичиг баримтыг барааг хүргэх газар, эсхүл боомтод ирэхээс 7 хоногийн өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> <p>9.4 Монгол Улсын дотроос санал болгосон бараа (ИКСБ):</p> <ol style="list-style-type: none"> <li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li> <li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li> <li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li> </ol>

<sup>7</sup>Эдгээр заалтуудыг зөвхөн жишээ болгож дурдсан / ба олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын мөрддөг жишиг/  
тухайн бараа нийлүүлэлтийн онцлогт тохируулан өөрчилж болно.

<sup>8</sup>Инкотермын аль нөхцөлийг ашиглахаас үүдэн бусад зохих бичиг баримтын нэрийг жагсаана.

		4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
		5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
5. Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН - 11)	11.1	Гүйцэтгэлийн баталгаа гэрээний үнийн 5 хувьтай тэнцэх дүнтэй байна.
6. Даатгал (ГЕН - 12)	12.0	Даатгалын тусгай шаардлага <b>шаардлагатай</b> . <b>Даатгалыг нийлүүлэгч байгууллага өөрөө хариуцна.</b>
7. Баталгаат засвар (ГЕН-13)	13.0	Баталгаат засварын тусгай шаардлага: <b>Машин, механизмын баталгаат хугацаа 1 жил байна.</b> [Гэрээний ерөнхий нөхцөлийн 13 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал гэрээний тусгай нөхцөлд тусгана.]
8. Төлбөр (ГЕН - 14)	14.4	ГЕН-ийн 14 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: <sup>9</sup> “Захиалагч Монгол Улсын гаднаас санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах журмын дагуу хийнэ: 1. Урьдчилгаа төлбөр: <b>Байхгүй</b> 2. Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр: <b>Байхгүй</b> 3. Барааг хүлээн авахад төлөх төлбөр: <b>тухайн ажлыг бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгснөөс хойш гэрээний үнийн нийт санхүүжилтийн 25-40 хувьтай тэнцэх дүнг бараа ирснээс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.</b> 4. Баталгааны төлбөр: <b>Нийт санхүүжилтийн 5 хувь</b>
9. Алданги оногдуулах (ГЕН - 17) <sup>10</sup>	17.1	Алданги оногдуулах хувь: <b>хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.01 хувь</b> Алдангийн нийт дүн: <b>Гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна.</b>
10. Маргааныг шийдвэрлэх (ГЕН - 21)	21.0	[ГЕН-ийн 21 дүгээр зүйлтэй уялдуулж ГТН-д шүүхийн байгууллагын тухай илүү дэлгэрэнгүй нөхцөлийг оруулна. Нийлүүлэгч Монгол Улсын хуулийн этгээд биш тохиолдолд олон улсын арбитрын байгууллагыг сонгож болно. Жишээлбэл, “Олон улсын худалдааны танхимын Арбитраж болон эвлэрлийн дүрмийн дагуу сонгогдсон арбитрын шүүгч энэ дүрмийн дагуу маргааныг шийдвэрлэнэ”. Арбитрын байгууллага маргаан шийдвэрлэх ажиллагаа явагдах улсыг заах ба арбитрын

<sup>9</sup> Энд дурдсан заалтууд болон хувиудыг зөвхөн жишээ болгож дурдсан бөгөөд /олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын мөрддөг жишиг/ тухайн бараа нийлүүлэлтийн онцлогт тохируулан өөрчилж болно.

<sup>10</sup> Монгол Улсын иргэний хууль

байгууллагын шийдвэр эцсийнх бөгөөд талууд заавал биелүүлэх үүрэгтэй болохыг мөн заана.

Захиалагч 1976, эсхүл 1980 оны НҮБ-ын Худалдааны комиссын (UNCITRAL) арбитрын дүрэм, Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төвийн арбитрын болон эвлэрлийн дүрэм эсвэл тус төвийн маргааныг шийдэх бусад дүрэм гэх мэт маргааныг шийдэх ижил төрлийн дүрмийг сонгож болно.]

---

**Хохирлыг барагдуулах**

*Барааны шинж чанарын улмаас ямар нэг алдагдал эсвэл хохирол гарсан бол нийлүүлэгч хохиролыг барагдуулах үүргээс чөлөөлөгдөхгүй.*

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### ГЭРЭЭНИЙ МАЯГТ

**БАТЛАВ.**

#### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

#### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № **[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]**

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ..... оны ..... сарын ..... -ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг ..... төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр, ..... төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ..... төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь ..... нэр төрлийн барааг ..... оны ..... дугаар сарын ..... -нээс ..... оны ..... дугаар сарын ..... -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>11</sup>;  
Тендер ба үнийн хуваарь;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Гэрээний тусгай нөхцөл;

<sup>11</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

## ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

### **[Захиалагч байгууллагын нэр]**

**[Гүйцэтгэгчийн нэр]** нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь **[Гэрээний нэр ба ажлын төвч тодорхойлолт]** (цаашид “гэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

**[Банкны нэр]** (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс **[баталгааны дүн тоогоор, төгрөг][дүн үсгээр, төгрөг]<sup>12</sup>** –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг **[захиалагчийн нэр]**(цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан **[баталгааны дүн тоогоор, төгрөг][дүн үсгээр, төгрөг]**-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш /огноог оруулах/ хугацаанд хүчинтэйбайна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга

Огноо:

Хаяг:

---

<sup>12</sup> Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

## УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

### **[Захиалагч байгууллагын нэр]**

**[Гүйцэтгэгчийн нэр]** (цаашид “гүйцэтгэгч” гэх) ..... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... тоот **[Гэрээний нэр ба ажлын төвч тодорхойлолт]** гэрээ (цаашид “гэрээ” гэх)-ний өрөнхий нөхцөлийн 48 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэхээ баталж **[Захиалагчийн нэр]-ийн** өмнө хариуцлага хүлээж **[Баталгааны мөнгөн дүн][үсгээр]**<sup>13</sup>-ийн банкны баталгаа ирүүлэхтэй ХОЛБОГДУУЛАН,

**[Банк нэр]** (цаашид “Банк” гэх) нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс **[баталгааны дүн тоогоор, валюты][дүн үсгээр, валюты]**<sup>14</sup>-ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг захиалагчийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, түүний дагуу гүйцэтгэх ажил, гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэхүү баталгаа нь гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид дээр дурдсан дүнтэй ижил төлбөр эргэн төлөгдөх өдөр /огноог оруулах/ хүртэлхүчин төгөлдөр байна.

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

<sup>13</sup> Энэ дунг банк, эсхүл санхүүгийн байгууллага бөглөх бөгөөд урьдчилгаа төлбөрийн үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь урьдчилгаа төлбөрийн валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгднэ.

<sup>14</sup> Энэ дунг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгднэ.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 07 сарын 02

Тендер шалгаруулалтын нэр: **МАШИН, МЕХАНИЗМ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖИЛ**

Тендер шалгаруулалтын дугаар: **УБЗЗАГОНӨААТҮГ/202003063**

**“УЛААНБААТАР ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ** эрх бүхий тендерт оролцогчдоос **МАШИН МЕХАНИЗМ НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫГ**-ыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000** /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 1 /нэг/ хувьтай тэнцэх хэмжээний тендерийн баталгаа ирүүлнэ.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг **2020 оны 07-р сарын 17-ны өдрийн 10 цаг 30 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 07-р сарын 17-ны өдрийн 11 цаг 00 минутад “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-ын Хурлын өрөөнд нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 14 дүгээр хороолол-6 Жуков, ”Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ- н 2 давхарт 211 тоот,**  
**утас:90792808**